

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖИЛЛАГААНД МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ АШИГЛАХ НЬ

Ганбатын Хосбаяр
ДХИС-ийн Удирдлагын академийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага,
стратегийн профессорын багийн дэд профессор,
хууль зүйн магистр, хошууч

Товч агуулга: Өгүүлэлд хорих байгууллагын аюулгүй байдлыг хангахад мэдээллийн технологийг ашиглах хэрэгцээ, боломж, мөн хэрэгжилтийн талаар, цаашид анхаарах асуудлын талаар судлаачийн байр суурийг илэрхийлсэн.

Түлхүүр үг: Хорих байгууллага, хорих байгууллагын аюулгүй байдал, мэдээллийн технологи, хиймэл оюун, хэрэгжилт, анхаарах асуудал.

Оршил

Хүн төрөлхтөн мэдээллийн технологийн харилцаанд суурилсан өвөрмөц нийгэмшлийн эрин үед амьдарч, цаг хугацаа, орон зайнаас үл шалтгаалан хүний өдөр тутмын хэрэглээнд нэвтэрч, салшгүй нэгэн хэсэг болсон зүйл бол орчин үеийн техник, технологи юм.

Орчин үеийн техник, технологийн хөгжил, цахим шилжилт, аж үйлдвэржилтийн IV хувьсгалийн өнөө үед мэдээллийн технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх асуудал чухлаар тавигдаж, энэ нь тухайн байгууллагын хөгжлийг тодорхойлох нэгэн чухал шалгуур үзүүлэлт болжээ.

Энэхүү техник, технологи нь хүний амьдралд хэрхэн нөлөөлж, ирээдүйд хэрхэн хувьсан өөрчлөгдөх, хөгжлийн ямар үе шатанд хүрэх нь “ирээдүй судлалын шинжлэх ухаан”-ны судлагдахууны чухал хэсэг болж байна.

Аливаа шинжлэх ухааны түүх, хөгжлийн чиг хандлага, зүй тогтол, онцлог нь хүн төрөлхтний оюун санааны хөгжлийн бодит үр дүнгээр илэрхийлэгддэг учир тухайн үзэгдэл, үйл явцыг үнэн зөв танин мэдэхэд юуны өмнө үүсэл хөгжил, харилцан хамаарал, өнөөгийн байдал, хандлагыг нэн тэргүүнд судлах шаардлагатай.

Өнөө үед техник, технологийн хөгжлийг, тэр дундаа мэдээллийн технологийг батлан хамгаалах, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд өргөнөөр ашиглаж байгаа ч, түүнийг хүн төрөлхтний хөгжлийн эсрэг ашиглан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, тагнан турших, хорлон сүйтгэх ажиллагаанд өргөнөөр ашиглаж, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал нь аль нэг улс орны бус олон улсын шинж чанартай болж байна.

Бидний амьдарч буй энэ цаг үе түүхийн хөгжлийн өмнөх шатуудаас олон зүйлээр ялгарах бөгөөд тэдгээрийн тоонд мэдээллийн технологийн хурдацтай хөгжил, түүний үр дүнг хэрэглээнд ашиглах явдал хамаарна.

Орчин цагийн төрийн байгууллага тэр дундаа хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын хөгжлийн стратегид хуулиар хүлээсэн чиг үүргийг орчин

үеийн мэдээллийн технологитой уялдуулан хэрэгжүүлэх, инновацид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд нэвтрүүлж, хэрэгжилтийг хангах нь аюулгүй байдал судлалын чухал судлагдахуун гэж үзэж болно.

Үндсэн хэсэг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын нэг бөгөөд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан болон шүүхээр хорих ял шийтгэгдсэн этгээдийг хуульд заасан дагуу нийгмээс тусгаарлаж, эрүүгийн хариуцлагын зорилгыг хангадаг бөгөөд хорих байгууллагын аюулгүй байдлыг биечилсэн болон техник, технологийн хяналт хамгаалалтын тусламжтайгаар зохион байгуулдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 204 дүгээр "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай"¹²³ тогтоолоор хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэмийг шинэчлэн баталж, хаалттай-7, нээлттэй-9, нээлттэй, хаалттай дэглэмтэй 3 хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага-1, нэгдсэн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг-2, эмэгтэйчүүдийн хорих анги-1, нийт 23 хорих анги, цагдан хорих төв-1, орон нутагт 25 цагдан хорих байртайгаар хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр тогтоолоор батлагдсан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 7.3.2-т "...гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлнэ", "Хууль сахиулах болон тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын үүрэг гүйцэтгэх чадавхыг олон улсын түвшинд өрсөлдөх хэмжээнд хүргэсэн байна", Хууль сахиулах салбарын хөгжлийн 7.4-т "Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, салбарын алба хаагчдыг бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлсэн байна", "Салбарын үйл ажиллагаанд шинжлэх ухааны өндөр түвшний технологийг нэвтрүүлэх бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, судалгаа, шинжилгээний баазыг бэхжүүлсэн байна", "Салбарын үйл ажиллагаанд технологийн дэвшилд суурилсан, хүний оролцоог багасгасан, ухаалаг системүүд нэвтэрсэн байна"¹²⁴, мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 7.4.27-д "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын технологийн дэвшлийг инновацад суурилан хөгжүүлнэ", 7.4.31-т "Дараа үеийн суурин болон хөдөлгөөнт холбооны технологийн дэвшилд

¹²³Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 204 дүгээр тогтоолын хавсралт.

¹²⁴Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" тогтоолын нэгдүгээр хавсралт. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ хот., 2020 он. №25

тулгуурласан цагдаа, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны онцлог тохирсон харилцаа холбооны шийдлийг нэвтрүүлнэ”¹²⁵ зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгагдсан нь хорих байгууллагын аюулгүй байдал, харуул хамгаалалтын үйл ажиллагаанд мэдээллийн технологи, инновацид суурилсан техник хэрэгслийг нэвтрүүлэх чиг хандлага нэгэнт бий болжээ.

Хорих байгууллагын аюулгүй байдал, харуул хамгаалалтыг эрүүгийн гэмт хэргийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх арга хэлбэр, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох шаардлага үүсч байна.

Тухайлбал, сүүлийн жилүүдэд авилга, албан тушаал, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, хүний амь нас, эрүүл мэндэд хүч хэрэглэн халдсан гэмт хэрэг үйлдэгсдийн тоо эрчимтэй нэмэгдэж, дийлэнх хувь нь хорих ялаар шийтгүүлж байна.

Сүүлийн 3 жилийн статистик тоо, дүн мэдээнээс үзвэл 2017 онд батлагдсан эрүүгийн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд цагдан хоригдогсдын тоо 1100 аас 1500 болж 40 хувиар, баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн хүний тоо 120-иос 400 болж 2.3 хувиар, нээлттэй дэглэмд ял шийтгэгдсэн хоригдлын тоо 1363-аар буюу 1.02 хувиар тус тус нэмэгдсэн¹²⁶ байна.

Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий харуул хамгаалалтын алба хаагчид 24 цагийн хугацаатай үүрэг гүйцэтгэж, 48 цаг амарч байгаа нь Хөдөлмөрийн хуульд заасан ажил, амралтын цагийн зохицуулалтыг зөрчихийн зэрэгцээ, ажлын ачааллыг эрс нэмэгдүүлж, түүнчлэн алба хаагчийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөөлж улмаар хорих байгууллагын аюулгүй байдал, харуул хамгаалалтад сөргөөр нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг үүсгэж байна.

Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох, алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих байгууллагын аюулгүй байдал, харуул хамгаалалтад инноваци, хиймэл оюун мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж хуулиар хүлээсэн чиг үүргийг нэг мөр хэрэгжүүлэх талаар шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний үндсэн дээр хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагатай.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд биелүүлэх, эрүүгийн хариуцлагын зорилгыг хэрэгжүүлэх, дотоод аюулгүй байдлыг хангах чиг үүргийн гүйцэтгэдэг.

Тус байгууллага нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн болон зохион байгуулалтын шинэтгэлийг үе шаттайгаар тасралтгүй хийж 1931 онд хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан бие даасан анхны хуулийг баталж байсан бол 1966, 1981, 1993, 1996, 2002, 2017 онуудад шинэчлэн баталжээ.

¹²⁵Мөн тогтоолын хоёрдугаар хавсралт.

¹²⁶ШШГЕГ-ын 2021 оны жилийн эцсийн тайлан.

2002 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар эрх зүйн болон бүтэц, зохион байгуулалтын томоохон шинэчлэл хийснээр хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хангах, хоригдлын ахуйн нөхцөлийн хангах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг олон улсын жишиг, хандлагад нийцүүлэхээс гадна хорих байгууллагын үйл ажиллагаанд хэт богино долгионы станц, телехяналтын техник хэрэгслийг нэвтрүүлэх, ашиглах эрх зүйн орчныг хуульчилсан нь хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх суурь тавигдсан гэж үзэж болно.

Тус үеэс хорих ял эдэлж байгаа этгээдийн талаас шинээр гэмт хэрэг үйлдэх, оргох явдлыг таслан зогсооход чиглүүлэн хорих ангиудад дохиолол, хамгаалалтын эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн төгөлдөржүүлэх арга хэмжээ авах, техник хэрэгсэл нэвтрүүлэх ажлыг эрчимтэй зохиожээ. Тухайлбал, гяндан, жирийн, чанга, онцгой дэглэмийн нийт хорих ангиуд, Ганц худаг дахь цагдан хорих төвийг бүхэлд нь телекамерын хяналтад оруулж, бусад цагдан хорих байрны 60.7 хувь, баривчлах байрны 80 гаруй хувийг телекамерын хяналтад хамруулсан байна¹²⁷.

Хорих байгууллагын аюулгүй байдал, харуул хамгаалалтын үйл ажиллагаанд тогтсон нэг технологи, арга хэрэгслийг ашиглах нь учир дутагдалтай.

Аливаа шинжлэх ухаан өөрийн хөгжлийн онцлог, судлах зүйл, судалгааны аргатай байх бөгөөд техникийн шинжлэх ухаан нь бусад шинжлэх ухааны салбарын үйл явцтай уялдаж, хөгжлийн процесст чухал үүрэг гүйцэтгэж байна.

Жишээлбэл, Бүгд Найрамдах Солонгос Улсын хорих байгууллага нь 2012 оноос эхлэн хорих ял эдлүүлэх болон хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд хиймэл оюунд суурилсан робот хянагчийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Энэ нь болзошгүй аюул, эрсдэлт хүчин зүйлсээс алба хаагчийг хамгаалсан, нөгөө талаас харуул хамгаалалтын үйл ажиллагаанд техник, технологийн дэвшлийг ашигласан анхны улс орон болсон.

Робот хянагчийн тусламжтайгаар биечилсэн болон техникийн хяналт хамгаалалтыг зохион байгуулахаас гадна, алсын зайнаас хоригдол, хоригдогчтой харьцах, биед рентген үзлэг хийх, хориотой эд зүйлсийг илрүүлэх, эрүүл мэндийн байдлыг тодорхойлох зэрэг олон дэвшилтэд үйлдлийг¹²⁸ гүйцэтгэх болжээ.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь “Ухаалаг хорих байгууллага бий болгох нь” зорилтыг дэвшүүлж дэлхийн хамгийн аюулгүй хорих ангийг байгуулах, менежментийн цогц чадварыг сайжруулах ажлыг хүрээнд хууль сахиулах үйл ажиллагаанд хиймэл оюунд суурилсан хөдөлгөөнт терминаль, хүний царай таних төхөөрөмж, жолоочгүй хуяглан хүргэлтийн тээврийн хэрэгсэл, мэдээллийн системд анализ хийх, мэдээллийн санд задлан шинжлэх замаар хорих ангийн үйл ажиллагааг “үйлдлийн дараах арга хэмжээ”-ээс “үйлдлийг хийхээс өмнөх хяналт”-

¹²⁷А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. УБ хот., 2008 он. 176 дахь тал.

¹²⁸ <https://www.digitaltrends.com/cool-tech/meet-south-koreas-new-robotic-prison-guards/>

д “мэдээллийг боловсруулах систем”-ээс “мэдээллийг урьдчилан таамаглах систем” рүү, ээлжийн ажил хүлээлцэх менежментийг ухаалаг төхөөрөмжийн менежментийн хэлбэр рүү шилжүүлэх боломжийг бүрдүүлжээ.

Тус улс нь “Ухаалаг хорих байгууллага” төслийн хүрээнд дараах 14 системийг нэвтрүүлсэн байна¹²⁹. Үүнд:

1. Видео аналитик хяналтын систем
2. Эрүүл мэндийн хяналтын систем
3. Явах хөдөлгөөний хяналтын систем
4. Мансууруулах бодис мэдрэгч автомат робот систем
5. Цахилгаан цоожны аюулгүй байдлыг систем
6. Байршлын мэдээллийг систем
7. Харилцаа холбооны нэгдсэн систем
8. Түлхүүр ба тоног төхөөрөмжийн нэвтрэх систем
9. Хоригдогчдын цахим шүүгээ
10. Хоригдогчдын өөртөө үйлчлэх ТҮЦ машин
11. Хоригдогчдын бие даан суралцах таблет
12. Робот хяналтын систем
13. Ухаалаг хяналтын систем
14. Албан хаагчдын гар төхөөрөмж зэрэг болно.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 260 дугаар зүйлийн 260.1.8-д “шүүхийн шийлвэр гүйцэтгэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг ашиглах, мэдээлэл дамжуулах болон бусад хяналтын систем нэвтрүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах”, мөн хуулийн 241 дүгээр зүйлийн 541.1.2-т “техникийн хяналт, хамгаалалт”¹³⁰ -ыг хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах бүрэлдэхүүн хэсэг гэж тодорхойлсон.

Хорих байгууллагын аюулгүй байдал, харуул хамгаалалтад дараах техник хэрэгслийн ашиглалтыг хамааруулсан. Тухайлбал, хорих байгууллага нь гадна хориотой бүс, хамгаалалтын хашаа, дулаан, хөдөлгөөн мэдрэх дохиолол, цахилгаан хүчдэлийн шугам, дүрс бичлэгийн хяналт бүхий зурвас, нэвтрэх хэсгийн дуу-дүрсний бичлэгийн хяналт зэрэг болно.

“Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”¹³¹-ийн 12 дугаар зүйлд цагдан хорих байрны харуул хамгаалалтыг хуульчилсан бөгөөд цагдан хорих төвийн гадуур болон дотуур хамгаалалтыг хорих байрны ажилтны хүчээр хариуцан гүйцэтгэж, бусад хорих байрыг хорих

¹²⁹Хонг Конг(БНХАУ)-ын хорих байгууллагын ахлах мэргэжилтэн Хуй Вай Ман. Хорих байгууллагын үйл ажиллагаа, нийгэмшүүлэх, олон нийтэд суурилсан засан хүмүүжүүлэх ял эдэлж бй хоригдогсдод хяналт тавих зэрэг үйл ажиллагаанд орчин үеийн техник технологийг ашиглах нь. Ази Номхон Далайн бүс нутгийн хорих байгууллагын удирдах ажилтнуудын 39 дүгээр бага хурал. 2019 он.

¹³⁰Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб хот., 2017 он. №41

¹³¹Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб хот., 1999 он. №34

байгууллагын албан хаагчид хамгаална, хорих байрны хамгаалалтад гэрэлтүүлэг, дохиолол, телехяналтын хэрэгсэл болон албаны нохой ашиглаж болно гэж заасан бөгөөд хамгаалалтын ажилтан галт зэвсэг, бусад тусгай хэрэгслээр хангагдах ба тэдгээрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэнэ гэж зохицуулсан.

Өгүүллийн зорилготой уялдуулан эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн холбогдох зарчим, төрөөс хорих ял эдлүүлэх чиглэлд баримтлаж буй бодлого, хорих ял эдлүүлэх, хоригдолд хяналт тавих харилцааг зохицуулж байгаа эрх зүйн эх сурвалжийн зарим хэм хэмжээ, хорих ял эдлүүлэх байгууллагын ангилал* ¹³², мөн мэдээллийн технологийг дэвшлийг хорих ял эдлүүлэх үйл ажиллагаанд ашиглах хэрэгцээ шшардлага, боломж нөхцөл, ач холбогдол, гарч болзошгүй эрсдлийн талаар товч авч үзье. Энэ нь:

- Хорих ял эдлүүлэх ажиллагаа **ялын зорилгыг**¹³³ хангахад захирагдах, хоригдолд байнгын, үр нөлөөтэй **хяналт тавих** зарчим;

- **Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.10/“Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх... ял эдлүүлэх ажиллагаанд цахим болон телехяналтын системийг нэвтрүүлэх, ялтныг хөдөлмөрт бүрэн хамруулах... замаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шинэтгэнэ”¹³⁴ /;**

- **“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны /7.3.2.Хорих байгууллагын тогтолцоог бүсчилсэн хэлбэрээр хөгжүүлнэ/; /7.3.3.Орон нутаг дахь цагдан хорих байрыг үе шаттайгаар шинэчлэх, олон улсын стандартад нийцсэн цагдан хорих, баривчлах байрыг шинээр барьж ашиглалтад оруулна/; /7.4.29.Хоригдогчдын хорих анги, байгууллагын дотоод үйлчилгээнд цахим картын системийг нэвтрүүлнэ/¹³⁵**

- **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 241.1 Г**Хорих ангийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь... **техникийн хяналт, хамгаалалт, биөчилсэн хяналт, хамгаалалт... гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байна**”, **243.3 Г”** Хоригдол, хорих ангийн алба хаагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хорих өрөө, хорих анги дотор хоригдол зорчих бусад хэсгийг хамарсан **дуу-**

¹³²Тухайлбал: Нийт хорих анги нь дэглэмийн хувьд: нээлттэй, хаалттай, байршлын хувьд нийслэл буюу Улаанбаатар хотын бүсэд 10 хорих анги, аймгийн төвд 7, хот, суурингийн гадна 8 хорих анги үйл ажиллагаагаа явуулж байна.

¹³³ Эрүүгийн хуулийн /2015 оны/ 5.1 дүгээр зүйлд “Эрүүгийн хариуцлагын зорилгонь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино”, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ хот, 2016 он, №7.

¹³⁴Монгол Улсын Их Хурлын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоол

¹³⁵Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

дүрсний бичлэгийн хяналтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зохион байгуулна¹³⁶”/;

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 267 зүйлийн 267.2 ГХорих байгууллага нь хорих ялыг албадан эдлүүлэх; /267.2.1/, хоригдлын аюулгүй байдлыг хангах. тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, хоригдол бусад этгээдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх; /267.2.2/, хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх; /267.2.3/, хоригдлыг хөдөлмөрлүүлэх, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд дадлага олгох; /267.2.4/ зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг”, **272 зүйлийн 272.1.3** ГХорих байгууллагын алба хаагч ... хоригдол. сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн бие, эд зүйл, байранд үзлэг, нэгжлэг хийх, зэвсэг. хутга. мэс, зэвсгийн чанартай бусад зүйл, мансууруулах болон хордуулах үйлчилгээтэй эм, тариа, өвс ургамал, согтууруулах ундаа, хориглосон тоглоом. хууль. дотоод журмаар зөвшөөрөгдсөнөөс бусад зүйлийг хураан авах, эсхүл устгах, бэлэн мөнгө, валют, үнэт зүйлсийг хураан авч акт тогтоон хадгалах, хорих ангийн аюулгүй байдал, түүнд мөрдөгдөх дэг журмыг сахиулах зорилгоор хоригдол. сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид **байнгын хяналт тавих**; бүрэн эрх эдэлнэ”¹³⁷ /

-“Хорих ангийн харуул хамгаалалтын журам”-ын 1 зүйлийн 1.4“Харуул хамгаалалтыг хорих ангийн байршил, дэглэм, зэрэглэл, алба хаагчдын орон тоо, зохион байгуулалт, хамгаалалтын бүс, байгууламж, инженер, техникийн хэрэгсэл, хоригдлын люог харгалзан биечилсэн хяналт-хамгаалалт, гадна хамгаалалт гэсэн хэлбэрээр зохион байгуулна”¹³⁸ /

-“Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах аюулгүйн тойрог тогтоох журам”-ын 1.1.1...хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, хоригдсон этгээд, хоригдлын зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх..¹³⁹;

-“Хорих байгууллагын аюулгүй байдал, хамгаалалт, хяналтын тоног төхөөрөмж, хүн нэг бүрийн агсамж, тусгай хэрэгслийн стандарт”-ийн 1.1 /...хорих байгууллагын харуул хамгаалалтад ашиглагдах хамгаалалтын байгууламж, хамгаалалтын техник, хэрэгсэл, сэжигтэн, яллагдагч, ялтныг хорих өрөө, харуул хамгаалалтын алба хаагчдын хүн нэг бүрийн агсамж, тусгай хэрэгслийг Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, заавар, стандартаар зохион байгуулж хорих байгууллагын аюулгүй байдлыг бүрэн хангах, орчинг нөхцөлийг сайжруулах...¹⁴⁰ зүйл тус тус болно.

¹³⁶ www.parliament.mn

¹³⁷Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, “Төрийн мэдээлэл эмхтгэл” УБ хот, 2017 он, №24

¹³⁸Хорих ангийн харуул хамгаалалтын журам, “Сүлд инфо”, УБ хот., 2017 он, №3

¹³⁹Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах аюулгүйн тойрог тогтоох журам, “Сүлд инфо”, УБ хот., 2017 он, №3

Судлаачийн үзэж байгаагаар хорих ял эдлүүлэх ажиллагаа, хорих байгууллагын аюулгүй байдлыг хангахад тулгарч байгаа бэрхшээлийн нэг бол улсын хэмжээнд байгаа харуул хамгаалалтын техник, хэрэгслийг шинэчлэх, нэвтрүүлэх асуудал юм. Тухайн асуудлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар тусгайлан зохицуулсан боловч улс орны нийгэм, эдийн засгийн чадавхи, цар тахал зэргээс шалтгаалж хэрэгжихэд хүндрэлтэй байдаг.

Монгол Улсын хэмжээнд хорих байгууллагад нийт 3300 гаруй хоригдол ял эдэлж, 1100 орчим хоригдсон этгээд цагдан хоригдож байгаа бөгөөд нийт ял эдлэгсдийг насанд хүрсэн хүн амын тоонд харьцуулж үзвэл 100.000 хүн ам тутамд 200 гаруй хоригдол ногдож байгаа нь бүс нутгийн хэмжээнд харьцуулж үзвэл бага бус үзүүлэлтэд тооцогдоно.

Ял эдэлж байгаа этгээдүүдийн ял шийтгэлийн байдалд судалгаа хийж үзэхэд анх удаа гэмт хэрэг үйлдсэн хоригдол 50% хувь, хоёр ба түүнээс дээш гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн хоригдол 45% хувийг тус тус эзэлж байна.

Энэ нь хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечилсэн хамгаалалтаар зохион байгуулах нь дутагдалтай бөгөөд техник, технологийн дэвшлийг ашиглаж хөдөлмөрийн нөхцөлийг дээшлүүлэх, цаг хугацаа хэмнэх, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг олон эерэг талуудыг бий болгоно гэж үзэж байна.

Дүгнэлт, санал

Гадаадын зарим орон орчин үеийн мэдээллийн технологи, техникийн дэвшлийг хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд нэвтрүүлснээр алба хаагчид тухайн орчин нөхцөлд хоригдол, хоригдогчийн нөхцөл байдлын талаар мэдээ, мэдээллээр хангагдаж, богино хугацаанд хуульд нийцсэн шийдвэр гаргахад тусалдаг. Мөн нөхцөл байдлын талаарх ойлголтыг сайжруулснаар ослын менежментэд илүү хурдан, үр дүнтэй хариу арга хэмжээ авах боломжийг бүрдүүлжээ.

Мөн хорих байгууллагын харуул хамгаалалтын алба хаагчдад тухайн ажилтны мэдлэг, ур чадвараас үл шалтгаалан мэдээллийг дүрслэн харуулах, урьдчилан мэдэгдэх, анхааруулах үйлдлийг үзүүлж, оновчтой шийдвэр гаргах боломжийг бий болгосон.

Ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд эрх зүйн шинэчлэл, орчин нөхцөл, ашиглагдах техник хэрэгсэл, байгууллагын үйл ажиллагааны болон хүний нөөцийн менежментэд инноваци хийх шаардлагатай болж байна.

Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүн-орчны харилцааг хууль, журмаар нарийвчлан зохицуулж, хүндээ чиглэсэн буюу хоригдол, хоригдогчийг нийгмийн хэм хэмжээнд нийцүүлэн бие даан амьдрах чадварыг эзэмшүүлэх, нийгэмшүүлэх хөтөлбөрүүдийг судалгаа шинжилгээний дээр тулгуурлан боловсруулж хэрэгжүүлэх, орчныг сайжруулахад чиглэсэн буюу орчин үеийн телехяналт,

хамгаалалтын тоног төхөөрөмжийг түлхүү ашиглан хяналт тавьж байгаа нь дэлхийн бусад орны ял эдлүүлэх ажиллагаанаас харагдаж байна.

Өндөр хөгжилтэй орнуудын хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь инноваци нь ухаалаг технологи буюу техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг өргөнөөр нэвтрүүлсэн явдал байна. Өөрөөр хэлбэл сүүлийн үед нэвтэрч буй инноваци нь ял эдэлж буй хоригдол, хоригдогчид ухаалаг технологийн тусламжтайгаар “өөрөө өөрийгөө хянах”-д үйл ажиллагаа руу чиглэгдэж байна.

Судлаачийн үзэж байгаагаар дэлхийн улс орнуудын хөгжлийн түвшин, нийгэм, эдийн засгийн чадавхи, хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчимтай уялдуулан хорих ял эдлүүлэх болон харуул хамгаалалтын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж хоригдол, хоригдогчийн хөдөлгөөн байршил, үйл хөдөлгөөнд хяналт тавих, хүн, эд зүйлсийг эрэн хайх, тодорхой үйлдэл, үйл ажиллагаа, фактыг олж тогтоох, бэхжүүлэх, нөхцөл байдлыг тодотгох, судлахад буюу дараах чиглэлээр ашиглах хэрэгцээ шаардлага, боломж байна гэж үзсэн. Энэ нь:

1. Хорих ангийн амьдралын, үйлдвэрлэлийн бүсийн гадна талбай, түүнчлэн ангийн байрлалаас гадна байгаа хоригдол, алба хаагч, ажилтны хөдөлгөөн, үйл ажиллагаа, байршилд хяналт тавихад;

2. Хоригдол, хоригдогчийн нүүр царай, дахин давтагдашгүй биометрик өгөгдлийг гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгалийн болон гэнэтийн давагдашгүй үйл явдал, мөн хорих ангид гарсан эмх замбараагүй байдлын үеийн үйл явцыг мэдээлэх, баримтжуулах, хүн, эд зүйлсийг эрэн хайж олох ажиллагаанд;

3. Болзошгүй эрсдлийг урьдчилан тооцоолох, хариу арга хэмжээ авахад;

4. Хорих анги, цагдан хорих төв, цагдан хорих байрнаас оргосон этгээдийг эрэн сурвалжлах, мөшгөн хөөх, баривчлах ажиллагаанд;

5. Хорих ангийн хамгаалалтын хашаа, хориотой бүсийг шалгахад;

6. Гэмт хэрэг, зөрчлийг урьдчилан сэргийлэх, илрүүлэх, нотлох баримтыг бэхжүүлэх ажиллагаа тус тус болно.

Иймд хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд мэдээллийн технологи, техник, тоног төхөөрөмжтэй холбоотой дараах зохицуулалт, практикийг бий болгохыг санал болгож байна. Энэ нь:

1. Хорих байгууллагад ашиглагдаж байгаа харуул хамгаалалтын хэрэгсэл болох телехяналтын систем, радио холбоо, дохиолол, үүрэн холбооны сүлжээ сарниулагч зэрэг технологийн шийдэл нь гадаадын болон дотоодын төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай харьцуулахад технологийн хувьд хоцрогдсон тул шинэчлэлт хийх;

2. Цахим шилжилт явагдаж буй өнөө үед төрийн үйлчилгээг нээлттэй, ил тод, түргэн шуурхай үзүүлэх зорилгоор “Ухаалаг хорих байгууллага” системийг

нэвтрүүлж, хэрэглэгч цаг хугацаа, орон зайнаас үл шалтгаалан хэрэглэх боломжийг нэвтрүүлэх;

3. Хорих байгууллагын аюулгүй байдал, харуул хамгаалалтад хиймэл оюунд суурилсан ухаалаг хяналтын аналитик програм, техник хэрэгслийг нэвтрүүлж, хоригдол, хоригдогсдод тавих хяналт-хамгаалалтыг сайжруулж, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах;

1. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн мэдээллийн технологи, тоног төхөөрөмжтэй холбоотой гадаадын орнуудын эрх зүйн зохицуулалт, практикийг судлан дэвшилтэд хэм хэмжээ, жишгийг өөрийн орны нөхцөл байдалд нийцүүлэн нутагшуулан хэрэгжүүлэх, мөн сөрөг үзэгдэл, үйл ажиллагаанаас сургамж авч холбогдох урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, тэмцэх арга хэмжээг авах шаардлагатай.

Эх сурвалжийн жагсаалт

Нэг. Эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017 он.
3. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, 1999 он.
4. Эрүүгийн хууль, 2015 он.
5. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 204 дүгээр тогтоол.
6. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” тогтоол
7. Хорих ангийн харуул хамгаалалтын журам, “Сүлд инфо”, УБ хот., 2017 он.
8. Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах аюулгүйн тойрог тогтоох журам, “Сүлд инфо”, УБ хот., 2017 он.

Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага

1. А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. УБ хот., 2008 он.
2. Хорих байгууллагын үйл ажиллагаа, нийгэмшүүлэх, олон нийтэд суурилсан засан хүмүүжүүлэх ял эдэлж бй хоригдогсдод хяналт тавих зэрэг үйл ажиллагаанд орчин үеийн техник технологийг ашиглах нь. Ази Номхон Далайн бүс нутгийн хорих байгууллагын удирдах ажилтнуудын 39 дүгээр бага хурал. 2019 он.

Гурав. Судалгааны ажил, тайлан

1. ШШГЕГ-ын 2021 оны жилийн эцсийн тайлан.

Дөрөв. Цахим эх сурвалж

1. <https://www.digitaltrends.com/cool-tech/meet-south-koreas-new-robotic-prison-guards/>
2. www.parliament.mn/